



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/969

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2015 оны 509 дүгээр тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 3/08 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.3.4, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 02/22 дугаар, 2018 оны 53 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Соёлын үйлдвэрлэл" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах, энэ захирамжийн хавсралтаар баталсан 9,420,000 /есөн сая дөрвөн зуун хорин мянган/ төгрөгийг нийслэлийн 2018 оны төсөвт тусгасан "Зүүн хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн төв болох арга хэмжээний зардал"-аас гаргахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга /М.Отгонбаяр/-т зөвшөөрсүгэй.

2. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч-Нийслэлийн Засаг даргын орлогч Ш.Анхмаад даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

С. БАТБОЛД

111020004062

Нийслэлийн Засаг даргын 2018 оны
 10 сарын 12-ны өдрийн
 А.С.Б.З.С.М. захирамжийн хавсралт

"СОЁЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ" ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ 2018 ОНД
 ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРДАЛ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1. Нийслэлийн соёл урлагийн байгууллагын хөрвөх чадварыг нэмэгдүүлж соёлын үйлдвэрлэлийг кластерийн зарчмаар хөгжүүлэх төсөл боловсруулах судалгааны ажил хийх					
1	Судалгааны багийн ажлын хөлс	Хүн	4	1200 000	4800 000
2	Судалгааны ажлын бичиг хэргийн зардал	багц	1	700 000	700 000
3	Байгууллагууд тус бүр дээр очиж нөхцөл байдлын шинжилгээ хийх судлаачдын унааны зардал / Багануур дүүрэг, Багахангай дүүрэг, Налайх дүүрэг, Сонгинохайрхан дүүрэг 21 -р хороо, хот дотор/	Км/литр	1000 кмх 8л	800 000	800 000
Дүн					6 300 000
2. Нийслэлд Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж нөхцөлийн талаар үйлдвэрлэл эрхлэгчид мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачдыг хамруулсан зөвлөлдөх уулзалт зохион байгуулах					
1	Уулзалт зохион байгуулах байрны түрээс	цаг	5 цаг	300 000	1500 000
2	Цайны завсарлага /Цай, кофе, печень/	Хүн	300 хүн	1000	300 000
3	Бичиг хэргийн зардал /Тараах материалын хэвлэлт/	ш	300	1000	300 000
4	Илтгэгчдийн урамшуулал	хүн	5	200 000	1000 000
5	Баннер /хөлтэй /	ш	1	20 000	20 000
ДҮН					3 120 000
НИЙТ ДҮН					9 420 000